

ХЯНАЛТАД АВСАН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2015 оны 04 дугаар сарын 07

Улаанбаатар хот

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хяналтад байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	Нийслэлийн Мал хамгаалах сан байгуулах тухай 2014.03.14 А/166	<p>1. Нийслэл дэх Мал хамгаалах сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Мал хамгаалах сангийн зөвлөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай.</p> <p>3. Сангийн ажлыг хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг Мал хамгаалах сангийн зөвлөлийн даргад үүрэг болгосугай.</p>	- Зөвлөлийн гишүүдийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөөг батлуулах	Мал хамгаалах сангийн данс нээлгэх хүсэлтийг НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн ба Сангийн яамнаас тусгай сангуудыг нэгтгэж Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх нэгдсэн данстай болох чиглэлийн дагуу Мал хамгаалах сангийн дансыг тус дансанд харьяалагдах болсныг Санхүү, төрийн сангийн хэлтсээс мэдэгдсэн. Сангийн зөвлөлийн гишүүдийн хурлыг хуралдуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна.	10
2	Улаанбаатар хотод ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах тухай 2014.03.18 А/178	<p>1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2 дугаар заалт, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага" баримт бичигт тусгагдсаны дагуу хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвийг төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй ачаа тээврийн терминалуудын өнөөгийн байдалд аттестатчилал явуулан дүнг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /М.Ням-Очир/, нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.</p>	- Газрын дуудлага худалдааны үнийг графикийн дагуу төлүүлэх, газар эзэмших эрхийг Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв" ХХК-д шилжүүлэх	Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв" ХХК-ийн үүсгэн байгуулагчдын хурлыг хуралдуулан газрын дуудлага худалдааны үнийг логистик төв ашиглалтанд орсноос хойш 5 жилийн дараагаас эхлэн графикийн дагуу 5 жилийн хугацаанд төлж барагдуулах шийдвэр гарган, саналыг НЗД-ийн орлогч Т.Бат-Эрдэнэд танилцуулаад байна. Орлогч дарга Т.Бат-Эрдэнэ, Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, Өмчийн харилцааны газрын орлогч дарга М.Батсайхан, газрын үнэлгээ төлбөрийн хэлтсийн мэргэжилтэн С.Ундармаа, Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэлийн асуудал хариуцсан орлогч дарга М.Дондогдорж, мэргэжилтэн Ч.Батхүү, "Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв" ХХК-ий захирал Г.Отгонбаяр болон оролцогч компанийн төлөөлөл нарын бүрэлдэхүүнтэй хуралдаж, газар эзэмших эрхийг "Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв" ХХК-д шилжүүлэхээр ажиллаж байна.	30

3	Журам батлах тухай 2014.05.30 А/450	1. Нийслэлийн хэмжээнд “Мал аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай 2. “Мал аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих журам”-ыг хэрэгжүүлэх ажлыг жил бүрийн зорилт, төлөвлөгөөнд тусган, удирдан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай	- Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын судалгааг авч шинэчлэх	“Мал аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих журам”-ыг хэрэгжүүлэх 2015 оны ажлын төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 11 заалт бүхий ажлыг төлөвлөн, газар, хэлтсийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мал аж ахуйн хоршоодын шинэчилсэн судалгааг авч нэгтгэж, судалгааг баяжууллаа.	30
4	Хөтөлбөр, журам батлах тухай 2014.05.30 А/451	1. “Нийслэлийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	- 2015 оны ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах - Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.	“Цогцолбор ферм байгуулах” ажлын нэгдсэн төсвийн төслийг боловсруулан Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-ийн төслийн багд холбогдох материалын хамт хүргүүлэн ажиллаж байна. 2015 онд эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 12 төрлийн сургалтыг зохион байгуулахаар сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гахай, тахианы аж ахуйн сургалтыг зохион байгуулж 12 иргэнд сертификатыг олгоод байна. Фермийн аж ахуйн сургалтыг 4 дүгээр сард ХААИС-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.01.08 А/01	1. Нийслэлийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын 2015 оны санхүүгийн жилийн анхны дансны гүйлгээ хийгдэх хугацаанаас эхлэн шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ажиллахыг нийслэл, дүүргийн бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	- 2015 оны шилэн дансны сайтад мэдээлэл оруулах төлөвлөгөө гарган батлуулах - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг хангаж ажиллах	Шилэн дансны сайтад мэдээлэл оруулах төлөвлөгөө гарган, газрын даргаар батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тухай бүр хугацаанд нь цахим хуудсанд оруулж байна.	90
6	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай	1. Үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, тэдний туршлагыг харилцан солилцуулах, үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийг олон нийтэд сурталчлах зорилгоор “Монголд	- Үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах	"Монголд үйлдвэрлэв-2015" үзэсгэлэнг зохион байгуулахаар Аж үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хамтарсан тушаал захирамж гарч худалдаа 2015-01-27-оос 2015-02-04 хүртэл Мишээл экспо төвд зохион байгууллаа.	100

	2015.01.22 12/A-58/A-06	<p>үйлдвэрлэв, Цагаан сар -2015” үзэсгэлэн, худалдааг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, үзэсгэлэн, худалдааны шилдэг бүтээгдэхүүнийг Шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг гуравдугаар, Шилдэг бүтээгдэхүүн шалгаруулалт явуулах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.</p> <p>2. “Монголд үйлдвэрлэв, Цагаан сар -2015” үзэсгэлэн, худалдааг зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр дүнг нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт тайлагнахыг үзэсгэлэн худалдаа зохион байгуулах Ажлын хэсэг /Д.Баттогтох/-т үүрэг болгосугай.</p>		<p>Үндэсний үйлдвэрээ сурталчилах, дэмжих, импортын бүтээгдэхүүний хэрэглээг багасгах зорилготой “Үндэсний Үйлдвэрлэлээ дэмжицгээе” уриатай зохион байгуулж буй эл үзэсгэлэнд хүнсний 48 томоохон үйлдвэр, сүү цагаан идээ үйлдвэрлэгч 30 аж ахуй нэгж, нийт 80 гаран аж ахуйн нэгж, хүнсний үйлдвэр эрхлэгчид оролцож байгаа юм.</p> <p>Энэхүү үзэсгэлэн худалдаанд нийслэлийн 6 дүүрэг, байнгын ажиллагаатай “Монголд үйлдвэрлэв” худалдааны 2 төвөөр дамжуулан нийт 800 гаруй аж ахуйн нэгж болон өрхийн үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид оролцлоо.</p> <p>Зохион байгуулагчдын зүгээс уламжлалт Цагаан сарын баяраар дотоодын үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр баярын ширээгээ засч, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хайртай дотны хүндээ гарын бэлэг барьж үндэсний хувцсаар гангарах уриалга гаргалаа.</p>	
7	Журам батлах тухай 2015.01.26 A/69	<p>2. “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ыг байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	<ul style="list-style-type: none"> - Журмыг албан хаагчдад танилцуулж, мөрдлөг болгон ажиллах - Журмын хэрэгжилтэд хяналт тавих - Тайланг улирал бүр хүргүүлэх 	<p>Журмыг байгууллагын нийт албан хаагчдад танилцуулан уулзалтын хуваарь гаргаж, газрын даргаар батлуулан, байгууллагын вэб сайтад байршуулсан. Мөн хэлтэс бүрийн уулзалтын дэвтрийг шинэчлэж, байгууллагын нэг өрөөнд уулзалтын тусгай хэсэг үүсгэсэн. Уулзалтын 1 дүгээр улирлын тайланг Нийслэлийн Засаг Даргын тамгын газрын Нутгийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн.</p>	70
8	Хөрөнгө гарах тухай 2015.02.16 A/138	<p>“Нийслэлийн тэргүүний фермер”, “Нийслэлийн сайн малчин”, “Нийслэлийн тэргүүний тариаланч”, “Нийслэлийн тэргүүний тариаланч” хамт олон шалгаруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн хөдөө аж ахуйн салбарын тэргүүний хүмүүсийг шалгаруулах ажлыг зохион байгуулах 	<p>Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүргээс “Нийслэлийн тэргүүний фермер 9, Нийслэлийн сайн малчин 3, Нийслэлийн тэргүүний тариаланч 2, “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон” 2-ыг шалгаруулж Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 27.047.600 төгрөгийг шагналд зарцууллаа. Шагналыг 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн удирдлагууд гардууллаа.</p>	100
9	Зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгох тухай 2015.03.12	<p>2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын</p>	<ul style="list-style-type: none"> - Тушаал гаргах 	<p>Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн даргын 2015.04.01-ний өдрийн Б/04 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2015.04.01-ний өдрөөс эхлэн олгож эхэлсэн.</p>	100

	A/181	Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, түүний харьяа хэлтсүүдийн дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.			
10	Ажлын хэсэг байгуулах тухай 2015.03.17 A/190	1. “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг зохион байгуулах Удирдах хороог нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.		2015 оны төсвийн тодотголоор нэмж 2,0 тэрбум төгрөгийг батлуулж, нийт 2 тэрбум 813 сая төгрөгийн санхүүжилтийн асуудал шийдэгдсэн. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламж барих тендерийн баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан.	10
11	Журам хүчингүй болгох тухай 2015.03.25 A/219	Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/451 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг хүчингүй болгов.	- НИТХТХ-ын тогтоол гаргуулах	Журмыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр Засаг даргаас өргөн бариад байна.	30
12	Ноос боловсруулах үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.03.30 A/230	2. Аж үйлдвэрийн яам, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэхийг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т даалгасугай.	- Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг ханган ажиллах - Орон нутагт байгуулсан үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах,	Засгийн газраас ноос боловсруулах үйлдвэрүүдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Өвөрхангай, Баянхонгор, Төв, Хэнтий зэрэг аймгуудад 12 ноос угаах үйлдвэр үйлдвэрийн барилга байгууламжаа барин, тоног төхөөрөмжөө суурилуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрээ шилжүүлэн Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод байршуулж байгаа Ноос Ирээдүй ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаатай Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын удирдлагууд болон Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны төлөөлөл 2015 оны 02 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд танилцлаа. Улаанбаатар хотод малын гаралтай ноосон түүхий эдийг оруулахгүй байх талаар. Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын удирдлагууд, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны удирдлагуудтай уулзах уулзалтыг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион	30

			<p>уулзалт зохион байгуулах</p> <p>- Арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд стандартыг мөрдөх ажлыг мэргэжлийн байгууллагуудт ай хамтран зохион байгуулах</p>	<p>байгууллаа.</p> <p>Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг 2015 оны 04 дүгээр сарын 8-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ний өдрүүдэд хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
--	--	--	---	--	--